



**БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

Хувилбарын дугаар: 02
Хүчин төгөлдөр болсон огноо: 2023.10.17
Баримт бичгийн дугаар:03

| | | | |
|------------------------------------|-----------------------------|---|--------------------|
| Баримт бичгийг хариуцах нэгж | | | |
| Баримт бичгийн нууцлалын зэрэглэл: | Дотоод | Баримт бичгийн түвшин | 2 |
| | | Албан тушаал | Гарын үсэг |
| Боловсруулсан: | Ц.Лувсандамдин Л.Золзаяа | ЭМТҮЧАБА-ны дарга Чанарын менежер | <i>А.Бөгдөө</i> |
| Санал өгч хянасан: | Д.Аззаяа Д.Болормаа | Гүйцэтгэлийн удирдлага дотоод хяналтын алба ЭЭДЗ | <i>[Signature]</i> |
| Хянаж батласан: | Г.Дашжанцан | БОЭТөвийн захирал | <i>[Signature]</i> |



Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл

| Хувилбарын дугаар | Хүчин төгөлдөр болсон огноо | Өөрчлөлтийг батласан албан тушаалтан | Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсонг товч тайлбарлана) |
|--------------------------|------------------------------------|---|--|
| 1 | | БОЭТ-ийн захирал Г.Дашжанцан | Баримт бичгийн хоёрдахь хувилбар |
| 2 | | | |
| 3 | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

АГУУЛГА:

| | |
|---|----|
| ЗОРИЛГО..... | 4 |
| ХАМРАХ ХҮРЭЭ..... | 4 |
| НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД..... | 4 |
| ПРОЦЕССИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА | 6 |
| ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БОЭТ-ИЙН БОДЛОГО..... | 9 |
| ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИХ ТОДРУУЛАХ..... | 11 |
| ҮР ДҮНТЭЙ ХАРИЛЦААГ БИЙ БОЛГОХ ЖУРАМ..... | 17 |
| ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН АЮУЛТАЙ/СЭРЭМЖЛҮҮЛЭХ ХЯЗГААРТ ХҮРСЭН ТОХИОЛДОЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ..... | 18 |
| УНАХ ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ..... | 25 |
| ӨНДӨР ЭРСДЭЛТ ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ, ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ..... | 33 |
| ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ | 35 |
| ХАРИУЦЛАГА | 38 |

НЭГ. ЗОРИЛГО

Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөр үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах, түүнд учрах хор хохирлыг бууруулахын тулд эрсдэлийг удирдахад дэмжлэг үзүүлэх.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

БОЭТ-ийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан дагаж мөрдөнө.

ГУРАВ. НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД

3.1 Нэр томьёо

- **Эмч эмнэлгийн мэргэжилтэн:** БОЭТөвийн бүх түвшинд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, сувилагч, эх баригч, үйлчлэгч, жолооч, харуул, тогооч нарыг

- **Таних бугуйвч** -Үйлчлүүлэгчийн мэдээлэл бүхий тэмдэглэгээ.
- **БОЭТ**- Бүсийн оношилгоо эмчилгээний төв
- **ЭЭДЗ**-Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
- **ЭМТҮЧАБА**-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй

байдлын алба

- **ЭБЭК**- Эх барих эмэгтэйчүүдийн клиник
- **Яаралтай байдал**– Амь нас эрсдэх, амин эрхтний үйл ажиллагаа зогсох аюул шууд заналхийлсэн байдлыг хэлнэ.
- **Сэрэмжлүүлэх/Аюултай хязгаарт хүрсэн шинжилгээний дүн**- Шинжилгээний үр дүн лавлах хэмжээнээс хэт хазайж өвчтөний амь насанд аюул учруулах үр дүнг хэлнэ.

- **Халдвараас сэргийлэх хяналт**-Эмнэлгийн ажилтан, үйлчлүүлэгч болон эмчлүүлэгч эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагаа

- **Эмнэлгийн ажилтан**-Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмнэлгийн мэргэжилтэн, дэмжих болон удирдах үйл ажиллагаанд оролцож буй бүх ажилтан

- **Халдварын гинжин хэлхээ**- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар үүсэхэд нөлөөлж буй шалтгаан, хүчин зүйлс

- **Стандарт сэргийлэлт**- Халдвараас сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх суурь шаардлага

- **Халдвар дамжих замаас шалтгаалсан сэргийлэлт**-халдвар тараах чадамж өндөртэй бичил биетний халдвар дамжих замд чиглэсэн арга хэмжээ.

- **Аюултай хариу**- Үйлчлүүлэгчийн амь насанд аюултай эсвэл эмчилгээнд шууд нөлөө үзүүлж болох хэвийн бус шинжилгээний үзүүлэлтийг хэлнэ.

- **Явганаас унах гэдэг нь** гэнэт хяналтгүй, санаандгүй, зорилгогүй босоо байдлаа алдаж, эсвэл юманд тээглэж, тодорхой нэг түвшнээс өөр түвшинд шилжин хий гишгэж шал, газар, шат зэрэг гулсамтгай гадаргуу дээр гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр халтирч унах тохиолдол бөгөөд ямар нэг зүйл мөргөж, газарт унахыг хэлнэ.

- **Өндөр эрсдэлтэй эм гэж** эмийн эмчилгээний алдаа үүссэн тохиолдолд эмчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд сөрөг үр дагавар үзүүлэх буюу эмийн гаж нөлөө үүсгэх эрсдэлт өндөртэй эмийг хэлнэ.

- **Адил дуудагддаг, адил харагддаг эм гэж** эмийн анхдагч болон хоёрдогч

савлагааны харагдах байдал болон эмийн олон улсын ба худалдааны нэршил төстэй учраас андуурагдах эрсдэлтэй эмийг хэлэх бөгөөд өндөр эрсдэлт эмэнд хамруулж үзнэ.

• **Эмийн эмчилгээний алдаа гэж** эмийн эмчилгээнд хэрэглэх явцад эмчлүүлэгчийн эрүүл мэндэд хохирол /бие махбодын бүтэц, үйл ажиллагааны болон сэтгэл санааны/ үүсгэсэн болон үүсэж болзошгүй алдааг хэлнэ.

- **НЛТ** -Нэгдсэн лабораторийн тасаг
- **ДОТ** –Дүрс оношилгооны тасаг
- **САЗ**- Сувилахуйн арга зүйч
- **ЧХХ**- Чих хамар хоолой
- **ISBAR**
 - I: Identify- (танилцуулах)
 - S:Situation- (одоогийн байдлыг тодорхойлон хэлэх)
 - B:Background- (Өмнө энэ тохиолдол үүсэж байсан эсэх, эсвэл үүсэх эрсдэлийн тухай товч өгүүлэх)
 - A:Assessment -(үнэлгээ)
 - R:Recommendation, Request- (зөвлөмж, санал, хүсэлт)

3.2 Иш татсан баримт бичиг

- Эрүүл мэндийн тухай хууль 2011 оны 05 сарын 05
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль 2016 оны 05 сарын 22
- ISO 9001:2015 ЧУТ-ны стандарт
- Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023
- Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5095:2017 стандарт
- Унах бэртэх эрсдлийг үнэлэх түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019
- Эрүүл мэндийн байгууллагын чанар аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны чиглэл төлөвлөгөө батлах ЭМС-ын 2017 оны 514 тоот тушаал
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах зарим арга хэмжээний тухай ЭМС-ын 566 тоот тушаал
- Мэс заслын тусламж үйлчилгээний хяналтын хуудас хөтлөх зааварчилгаа Эрүүл мэндийн сайдын 2013 оны 177 тоот тушаал
- ЭМС-ын 2023. 06.22 А/220 Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам
- ЭМС-ын 2019.11.29 А/536, 537, 539 тоот тушаал
- ЭМС-ын 2022.07.04 А/352 Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам

ДӨРӨВ. ПРОЦЕССИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА / RACI МАТРИЦ /

| № | Процесс | Тасгийн эрхлэгч, эмчлэгч эмч | Түүх нээх ажилтан | Сувилагч | Эх баригч | Нийт эмнэлгийн мэргэжилтэн | Амбулатори, тасгийн эмч | ЭТҮЧАБА | ЭЭДЭ |
|------------------------------------|--|---------------------------------|----------------------|----------|-----------|-------------------------------|----------------------------|---------|------|
| 1. Үйлчлүүлэгчийг зөв таних | | | | | | | | | |
| 1 | Бугуйвчийн өнгөний кодыг тодорхойлох | RA | i C | I | I | I | I | I | |
| 2 | Бугуйвчийн мэдээллийг тэмдэглэх | I | RA | I | I | I | I | I | I |
| 3 | Бугуйвчийг зүүх авах | I | | RA | | I | I | | |
| 4 | Нярайн бугуйвч зүүх авах | I | I | I | RA | I | I | | |
| 5 | Үйлчлүүлэгчийн карт ба өвчтний түүхэнд хөгжлийн бэршээлтэйг таних тэмдэглэгээ хийх | I | I | I | I | I | RA | I | I |
| 6 | Үйлчлүүлэгчийн бугуйвчийн код, хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийн тэмдэглэгээг таньдаг байх | I | I | I | I | RA | | | |
| 7 | Зөв таних үйлдлийн хэрэгжилтийг хянах | I | I | I | I | | | RA | RA |

2.Үр дүнтэй харилцааг бий болгох, аюултай шинжилгээний хариуг мэдээлэх

| № | Процесс | Лаборант | Эмнэлзүйн эмгэг судлаач эмч | Эмчлэгч эмч | НЛ, ДОТ Бусад тасгийн эрхлэгч нар | ЭТҮЧАБА | ЭЭДЗ |
|---|---|----------|-----------------------------|-------------|-----------------------------------|---------|------|
| 1 | Шинжилгээг стандартын дагуу хийхэд аюултай сэрэмжлүүлэх хариу гарах | RA | C | | i | | i |
| 2 | Шинжилгээг дахин стандартын дагуу хийж баталгаажуулах | RA | C | RA | i | | |
| 3 | Эмчлэгч эмч, лабораторийн эмчид аюултай сэрэмжлүүлэх хариу гарсан тухай мэдээллэх | RA | C | | | | |
| 4 | Цахим программд шинжилгээний хариу оруулах | RA | | | | | |
| 5 | Аюултай шинжилгээ бүртгэх дэвтэрт тэмдэглэл хөтлөх | RA | | | | | |
| 6 | Хяналт тавих | | | | AC | AC | AC |

2. Өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдлыг сайжруулах

| № | Үйлдэл | ЭМХХА ба эрхлэгч | Сувилагч | Тасгийн эрхлэгч | Сувилахуйн алба САЗ | ЭЭДЗ | ЭТҮЧАБА |
|---|--|------------------|----------|-----------------|---------------------|------|---------|
| 1 | Өндөр эрсдэлтэй эмийн жагсаалтыг шинэчлэн гаргах | RA | i | A | C | i | |

| | | | | | | | |
|---|--|----|----|----|----|----|----|
| 2 | Өндөр эрсдэлт эмийн байршил, хаягжилт, хадгалалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулах зөвлөмжийг гарган | | | | RA | | |
| 3 | Эмийн түүвэрт өндөр эрсдэлтэй эмийн жагсаалтанд орсон эмийн нэрийг “BOLD” хэлбэрээр ялган тэмдэглэж өгөх | i | RA | i | | | i |
| 4 | Өндөр эрсдэлтэй эмийн хэрэглээнд хяналт тавих | RA | | RA | | RA | i |
| 5 | Үйлчлүүлэгчид эмийн эмчилгээг хийхийн өмнө өвчтнийг зөв таних, эмийн бодисын нэр тунг хэрэглэхийн өмнө 3 удаа шалгана. | | RA | | AC | | |
| 6 | Хяналт тавих | | | | | | RA |

3. Зөв өвчтөнд, зөв талбайд, зөв ажилбар хийх зарчим ба талбайн тэмдэглэгээ хийх

| № | Үйлдэл | Эмчлэгч эмч | Фильтер | Хагалгааны баг | ЭЭХНТ-ын нөлөөг эрхлэгч | ЭЭДЗ | ЧАБА |
|---|---|-------------|---------|----------------|-------------------------|------|------|
| 1 | Мэс засал, мэс ажилбарын талбайг арилахгүй балаар арьсан дээр тэмдэглэнэ. | RA | IC | A | C | i | i |
| 2 | Эмчлүүлэгчийг зөв таниж мэс заслын | | | | RA | | |

| | | | | | | | |
|---|--|--|----|----|----|--|----|
| | хэсэгт хүлээн авах | | RA | | | | |
| 3 | Хяналтын хуудасны алхам бүрийг чанга дуугаар асууж баталгаажуулна. /2 хувь/ | | | RA | | | i |
| 4 | Хяналтын хуудсанд үнэлгээ хяналт хийнэ. | | | | RA | | RA |
| 5 | Мэс заслын хэсгээс тасагт шилжихийн өмнө халдварын шинж тэмдэгээр тандах хуудсуудыг нээж, ногоон бугуйвчийг зүүнэ. | | | RA | | | |

4. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх

| № | Үйлдэл | Эмч, сувилагч, эх баригч, лаборант, туслах сувилагч , | Тасгийн эрхлэгч, сувилахуйн арга зүйч | Халдварын сэргийлэлт хяналтын алба | ЭТҮЧАБА | Санхүү | ЭЭДЗ |
|---|--|---|---------------------------------------|------------------------------------|---------|--------|------|
| 1 | Гар халваргүйтгэх, гар угаах | RA | | С | | С | |
| 2 | Асгарсан цацагдсан биологийн шингэнийг цэвэрлэх цомог бэлэн байлгах, ашиглах | RA | | С | С | | |
| 3 | Өртөлтийн дараах хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх | RA | | | | | |
| 4 | Хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу өмсөх, тайлах | RA | | | | | |
| 5 | Тусгаарлах өрөөний дэглэм бариулах, тэмдэг хэрэглэх | | RA | | | | |
| 6 | Орчны эрүүл зүйн шинжилгээг авах хянах | | С | RA | | | i |

| | | | | | | | |
|----|--|----|----|----|----|----|----|
| 7 | Эрүүл зүйн шинжилгээ авах нян тээгч илрүүлэх эрүүлжүүлэх арга хэмжээ авах | | RA | RA | | | RA |
| 8 | ЭТҮХХ сэргийлэх арга хэмжээний нөөц, нөхцлөөр хангах | | | | | RA | C |
| 9 | Халдварын шинжээр тандах хуудсаар тандах, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх | RA | RA | C | | | I |
| 10 | ЭТҮХХ-ын Сэжигтэй тохиолдлыг тандах судлах дүгнэлт гаргах хариу арга хэмжээг хэрэгжүүлэх | | | RA | | | C |
| 11 | ХСХ үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах | | | | | | RA |
| 12 | ХСХ үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмжөөр хангах | | | | RA | | |

5. Унах эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх

| № | Үйлдэл | Эмчлэгч эмч | Сувилагч | Сувилахуйн арга зүйч | Тасгийн эрхлэгч | Аж ахуйн алба | ЭТҮЧАБА |
|---|--|-------------|----------|----------------------|-----------------|---------------|---------|
| 1 | Унах эрсдлийг тогтоох | A | C | RC | C | | |
| 2 | Шар өнгийн бугуйвчийг зүүх | RA | RA | | RA | | |
| 3 | Унах эрсдлийн гадаад хүчин зүйлсийг илрүүлэх бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх | | | RA | | RA | i |
| 4 | Унах эрсдлийн дотоод хүчин зүйлийг нэмэгдүүлсэн эмнэл зүйн нөхцлийн үед бууруулах арга хэмжээг авах / эмийн хэрэглээ, унтуулга, гуурстай,/ | RA | RA | RA | A | | |

| | | | | | | | |
|---|----------------------------------|--|--|--|--|--|----|
| 5 | Журмын хэрэгжилтэнд хяналт тавих | | | | | | RA |
|---|----------------------------------|--|--|--|--|--|----|

/ R- гүйцэтгэх, А-хариуцах, С-хамтран ажиллах , I -мэдээлэлтэй байх /

ТАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, БОЭТ-ИЙН БОДЛОГО

5.1 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын үзэл баримтлал

- Эмнэлэгт хэвтэж байгаа 10 эмчлүүлэгч тутмын нэг нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой асуудалд өртдөг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой гарч буй таагүй үйл явдлын давтамж, түүнээс урьдчилан сэргийлэлтийн талаар дунд болон буурай хөгжилтэй 26 оронд хийсэн судалгаагаар таагүй үйл явдлын түвшин (сөрөг үйл явдал) 8% байсан байна. Үүний 83% нь урьдчилан сэргийлэх боломжтой байсан бөгөөд 30% нь үхэлд хүргэжээ.

- Эмийн зохисгүй хэрэглээ, Эмчилгээний буруу дадал, алдаа нь дэлхийн түвшинд эрүүл мэндийн тогтолцоонд байж боломгүй буюу зайлсхийж болох хор уршгийн гол шалтгаан болж байна. Эмчилгээний алдаа нь эмнэл зүйн тусламж, үйлчилгээний тогтолцоо сул нөхцөлд тохиолддог. Мөн хүний хүчин зүйлс тухайлбал ажлын хэт ачаалал, ажлын байрны тааруу нөхцөл, тогтворгүй байдал, хүний нөөцийн дутагдал зэрэг нь эмийн жор бичилт, бүртгэлт, түгээлт, удирдлага, хяналт-шинжилгээний үйл ажиллагаанд нөлөөлдөг ба хүнд хор уршиг учруулах, хөгжлийн бэрхшээл, тэр ч байтугай үхэлд хүргэж болдог байна.

- Эрүүл мэндийн зардлын 15 хувь нь тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой гарах таагүй (сөрөг) тохиолдлыг шийдэхэд зарцуулагддаг.

- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх таагүй тохиолдлыг бууруулахад хөрөнгө оруулалт хийх нь санхүүгийн ихээхэн хэмнэлт гаргахад хүргэнэ.

- Эмнэлгээс шалтгаалах халдварт 100 үйлчлүүлэгч тутмын 14 нь өртдөг болохыг хүлээн зөвшөөрсөн. Өндөр хөгжилтэй орнуудад хэвтэж эмчлүүлсэн 100 үйлчлүүлэгчийн тутмын 7, буурай болон дунд хөгжилтэй орнуудад 10 нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар авдаг. Европын холбооны орнуудад жил бүр 3.2 сая өвчтөн эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварт өртдөг бөгөөд тэдний 37,000 орчим нь нас баржээ. Энгийн, хямд өртөгтэй тухайлбал, гар угаалт зэрэг халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг авснаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын давтамжийг 50%-аас дээш бууруулж болдог байна.

- Жил бүр нэг сая гаруй өвчтөн мэс заслын хүндрэлээс болж нас барж байна. Үйлчлүүлэгч төвтэй найдвартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тулд ДЭМБ-аас үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын сайжруулах стратегийн дараах гол чиглэлүүдийг баримтлан ажиллаж байна.

Үүнд:

- Үйлчлүүлэгчийг зөв таних- Identify Patients Correctly.
- Үр дүнтэй харилцааг бий болгох- Improve Effective Communication.
- Өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдлыг сайжруулах- Improve the Safety of High-Alert Medications.
- Зөв өвчтөнд, зөв талбайд, зөв ажилбар хийх зарчим ба талбайн

тэмдэглэгээ хийх- Ensure Correct-Site, Correct-Procedure, Correct-Patient Surgery.

- Эмнэлгээс шалтгаалах халдварыг бууруулах- Reduce the Risk of Health Care–Associated Infections.
- Эмнэлгийн орчинд явганаас унах эрсдэлийг бууруулах - Reduce the Risk of Patient Harm Resulting from Falls.

5.2 Өвчтөний аюулгүй байдлын талаар БОЭТ-ийн баримтлах бодлого

1. Үйлчлүүлэгчийг зөв таних
2. Үр дүнтэй харилцаа бий болгох
3. Өндөр эрсдэлтэй эмийн аюулгүй байдлыг сайжруулах
4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг бууруулах,
5. Эмнэлгийн орчинд унах эрсдэлийг бууруулах арга хэмжээг байнга авч хэрэгжүүлж, тогтмол сайжруулдаг байна.
6. Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөрт энэхүү журмыг багтаан ажилтан бүрийг бүрэн хамруулж дадлагажуулна.
7. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг тав тухтай үйлчлүүлэх, саадгүй орчин нөхцөлийг хангах зорилгоор шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
 - Тэргэнцэртэй иргэнийг саадгүй явуулах зам, бие засах газар тохижуулах
 - Дохионы хэлмэрч бэлтгэх
 - Тэргэнцрийн хүртээмж нэмэгдүүлэх
8. Антибиотикт тэсвэртэй нянг бууруулах тандалт хяналтыг хийж антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр тогтмол сайжруулалт хийнэ.
9. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тасаг нэгж, эмч эмнэлгийн мэргэжилтний оролцоог ажил дүгнэх шалгуурт оруулан улирал жилийн ажлыг дүгнэнэ

ЗУРГАА: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИХ ТОДРУУЛАХ

6.13 Зорилго: Бүсийн оношилгоо эмчилгээний төв (цаашид “Эмнэлэг” гэх)-ээр үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангахын тулд эмнэлгийн хэмжээнд бүхий л хугацаанд тасаг, нэгж бүр зөв аргаар үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийг таньж, аюулгүй байдлыг хангахад оршино.

6.2 Танин тодруулах ерөнхий зарчим

- Үйлчлүүлэгчийн хувь хүний өвөрмөц мэдээллийг ашиглана.
- Үйлчлүүлэгчийн хэвтэн эмчлүүлж буй ерөөний болон давхрын дугаар, орны байрлал, хувцаслалтыг танин тодруулгад ашиглахгүй
- Бугуйн зүүлтний өнгийг энэхүү ЭМС-ын 2022 оны A/352 тоот тушаалд заасны дагуу энэхүү журмын 3.11 заалтад тусгасны дагуу хэрэглэнэ.
- Үйлчлүүлэгчийг мөн эсэхийг тодруулахдаа асуухаас илүү өөрөөр нь хэлүүлэхийг чухалчилна.

6.3 Үйлчлүүлэгчийг танин тодруулах үйл ажиллагаа

6.3.1 Дараах тохиолдлуудад үйлчлүүлэгчийг танин тодруулга заавал хийнэ.

- Эмч үзлэг хийхийн өмнө
- Шинжилгээний сорьц авахын өмнө
- Эмийн эмчилгээний өмнө
- Дүрс оношилгоо, багажийн шинжилгээ хийхийн өмнө болон хариу хүргэх үед

- Сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэхийн өмнө
- Эмчилгээ, оношилгоо,ажилбарын өмнө
- Мэс засал, мэс ажилбарын өмнө
- Цус цусан бүтээгдэхүүн сэлбэхийн өмнө
- Хоол сойх, эмчилгээний хоол түгээхийн өмнө
- Үйлчлүүлэгч нас барах тохиолдолд

6.3.2 Дээрх үйлдэл бүрийн өмнө үйлчлүүлэгчийг зөв танин тодруулахдаа овог нэрийг чанга тод дуугаар дуудаж, үйлчлүүлэгчтэй хамт дахин овог, нэр, төрсөн он сар, өдрийг баталгаажуулна.

6.3.3 Хэрэв нэр, төрсөн огноо нь ижил хоёр үйлчлүүлэгч байвал эмнэлгийн бүртгэлийн дугаар, утасны дугаар, эсвэл гэрийн хаягийг үйлчлүүлэгчийг танихад ашиглана.

6.3.4 Тухайн тусламж үйлчилгээ бүрийн өмнө дараах аргуудаас хамгийн зохистой гэж үзсэн хоёроос доошгүй аргыг хэрэглэнэ. Үүнд:

- Овог нэр бүтнээр
- Нас хүйс асуух
- Төрсөн огноог асуух
- Гэрийн хаягийг хэлүүлэх
- Бугуйн зүүлт дээрх мэдээлэлтэй тулгах
- Бичиг баримт болон цахим санд бүртгэгдсэн зурагтай тулгах
- Хэвтэн эмчлүүлж буй тасгийг асуух

6.3.5 Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчилгээний аюулгүй байдлыг хангахын тулд үйлчлүүлэгчийг таних бугуйн зүүлтийг зүүнэ.

6.3.6 Хэвтүүлэх бичиг илгээж байгаа эмч үйлчлүүлэгчийг үнэлэн бугуйвчны өнгийг сонгож илгээнэ.

6.3.7 Эмнэлгийн цахим системд үйлчлүүлэгчийг бүртгэх үед шаардлагатай мэдээллийг эрүүл мэндийн ажилтан лавлан бугуйн зүүлтийг зүүнэ. /Цахим бүртгэгч, хөтөч, 103 деспечер сувилагч, түүх нээгч /

6.3.8 0-18 насны хүүхэд бол өөрөөс болон эцэг эх, асран хамгаалагчаас эмчлүүлэгчийн мэдээллийг асууж мэдээллийн санд бүртгэнэ.

6.3.9 Бугуйн зүүлтийг дараах үйлчлүүлэгчид хэрэглэнэ

- Амбулатори, яаралтай тусламж, үйлчилгээний 4 цагаас дээш хугацаагаар авах үйлчлүүлэгч
- Хэвтэн эмчлэх тусламж, үйлчилгээ авах үйлчлүүлэгч
- Өдрийн эмчилгээнд хамрагдаж буй үйлчлүүлэгч

6.3.10 Бугуйн зүүлтэнд үйлчлүүлэгчийн дараах мэдээлэл бичигдэнэ.

-Үйлчлүүлэгчийн эцэг/эх/-ийн нэр

-Төрсөн он,сар,өдөр

-Нас, хүйс

-Цахим бүртгэлийн дугаар

-Цусны бүлэг

-Хэвтэх тасаг

-Оношийн код

-Харшилтай эсэх

-Хэвтэх орны дугаарыг заавал тэмдэглэнэ.

6.3.11 Бугуйн зүүлтэд дараах мэдээллийг оруулахыг хориглоно. Үүнд:

-Товчилсон үг ашиглах

-Үйлчлүүлэгчийн хоч болон дуудах нэр ашиглах

6.3.12 Эмчлүүлэгчийг тасаг нэгжид хүлээн авсан эмнэлгийн ажилтан шаардлагатай мэдээлэл, эрүүл мэндийн байдал, эмнэлзүйн онцлог, хэрэглэх эм, тариа, тухайн тасаг, нэгжид ижил нэртэй үйлчлүүлэгч байгаа эсэхийг бугуйн зүүлтний өнгийг өөрчлөх эсвэл нэмж зүүж хэрэглэнэ.

6.3.13 Шинээр төрсөн нярайн бугуйвчийг энэхүү журмын дагуу эх баригч зүүж өгөх ба бугуйвчинд эхийн овог нэр нас, нярайн регистерийн дугаар, төрсөн өдөр цаг минут, нярайн жин өндөрийг тусган тэмдэглэгээ хийнэ.

6.3.14 Дархлаажуулалт хийсэн талаар нярайд дархлаажуулалт хийсэн ажилтан нэмэлт тэмдэглэгээ хийж өгнө.

6.3.15 Бугуйн зүүлтний өнгө нь дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:

- “Ягаан бугуйн зүүлтийг эрчимт эмчилгээний үйлчлүүлэгчид
- “Шар өнгө” бугуйн зүүлтийг унах эрсдэлтэй үйлчлүүлэгчид
- “Улаан өнгө” бугуйн зүүлтийг харшилтай /Эм тариа, хоол хүнс гм/
- “Цагаан өнгө” бугуйн зүүлтийг эрсдэлгүй, эмийн эмчилгээ, шинээр төрсөн нярайд хэрэглэнэ.
- “Цэнхэр өнгө” бугуйн зүүлтийг CODE BLUE, идэвхжүүлсэн үйлчлүүлэгч
- **Бугуйвчийн өнгөний код**

| Өнгөний код | Ногоон | Шар | Улаан | Цэнхэр | Цагаан |
|---|--------|-----|-------|--------|--------|
| Мэдээлэл | | | | | |
| Эрчимт эмчилгээний үйлчлүүлэг | | | | | |
| Унах эрсдэлтэй өвчтөн | | | | | |
| Харшилтай өвчтөн | | | | | |
| CODE BLUE идэвхжүүлсэн үйлчлүүлэгч | | | | | |
| Эрсдэлгүй, эмийн эмчилгээ, шинээр төрсөн нярайд хэрэглэнэ | | | | | |

6.3.16 Бугуйн зүүлтийг насанд хүрэгчдийг зүүн гарын бугуйн хэсэгт, хүүхдийг зүүн хөлийн шилбэнд зүүнэ.

6.3.17 Хэрэв зүүн гар тайрагдсан эсвэл зүүн гарт гуурс тоног төхөөрөмж холбогдсон бол баруун гарын бугуйнд зүүнэ. Хоёр гаргүй үед хөлийн шилбэнд зүүнэ.

6.3.18 Татгалзсан болон харшилтай үед тэмдэглэл үйлдэнэ, бугуйн зүүлт зүүлгэхгүй.

6.3.19 Ухаангүй болон дагалдан ирсэн хүнгүй таних боломжгүй тохиолдолд

өвчний түүхийн дугаар /яаралтай тусламжийн хуудасны дугаар/ бүхий бугуйвч зүүлгэнэ.

6.3.20 Эмчлүүлэгч эмнэлгээс гарах болон эмнэлэг хооронд шилжүүлэх үед бугуйн зүүлт авна .

6.3.21 Бугуйвчны мэдээлэл буруу болон арилсан тохиолдолд нэн даруй солино.

6.3.22 Эмчлүүлэгч нас барсан тохиолдолд бугуйн зүүлт дээрх мэдээллийг нягтлан, бугуйн зүүлтийг тайлалгүй шарил хадгалах өрөө рүү зөөвөрлөнө.

6.4 Харилцааны бэрхшээлтэй буюу аман харилцаа үүсгэх боломжгүй эмчлүүлэгчийг танин тодруулах

6.4.1 Харилцааны бэрхшээлтэй буюу аман харилцаа үүсгэх боломжгүй үйлчлүүлэгчид хамааруулна. Үүнд:

- Түр зуурын харилцааны бэрхшээлтэй / Ухаангүй, ихээр эм хэрэглэсэн, зохиомол амьсгалын аппараттай,эрчимт эмчилгээний тасагт байгаа, сэрээх өрөөний үйлчлүүлэгч/

- Гадаад улсын хэл нэвтрэлцэхгүй
- Нярай хүүхэд
- Танин мэдэхүйн алдагдалтай /тэнэгрэл, зан төрхийн өөрчлөлтийн эмгэгүүд/
- Хэлгүй, дүлий үйлчлүүлэгчийг харилцааны бэрхшээлтэйд хамааруулна

6.4.2 Дээрх үйлчлүүлэгчдийн мэдээллийг ар гэр, асран хамгаалагчаас мэдээллийг авна

6.4.3 Хэрэв хүний мэдээллийг тодруулах боломжгүй бол “Овоггүй ,Нэргүй” гэж нэрлэн цахим бүртгэлд бүртгэнэ, мэдээлэл тодорхой болсон даруйд мэдээллийг засаж бүртгэн бугуйн зүүлтийг хэрэглэнэ.

6.4.4 Шаардлагатай тохиолдолд дохионы хэл болон орчуулагчаар дамжуулан танин тодруулга хийнэ.

6.5 Мэс заслын үед танин тодруулах

6.5.1 Мэс засал хийхэд үйлчлүүлэгчид мэдээ алдуулалт болон унтуулга хийхээс өмнө буюу мэс заслын өрөөнд орохоос өмнө дараах танин тодруулга хийнэ.

- Үйлчлүүлэгчийн эцэг/эх/-ийн нэр, нэр
 - Регистрийн дугаар
 - Төрсөн он,сар,өдөр
 - Аль талын ямар эрхтний ямар мэс засалд орох гэж байгаа талаар
- 6.5.2 Бугуйн зүүлтийг үйлчлүүлэгчийг биеийн мэс засал хийгдэхгүй талд зүүнэ.
- 6.5.3 Мэс засал буюу мэс ажилбарын өмнө “Time-out” буюу “ Завсарлага” хийнэ.
- 6.5.4 Мэс заслын талбайн тэмдэглэгээг эмчлэгч эмч хийнэ.
- 6.5.5 Мэс заслын талбайд тэмдэглэл хийх:

- Үйлчлүүлэгчийн ухаан санааны байдал хэвийн байхад буюу унтуулга, мэдээ алдуулалт хийхээс өмнө хийнэ.
- Хос эрхтэн,олон мөчид ба нуруу нугалмын мэс заслын үед заавал хийнэ.
- Мэс засал хийх эмч арьсны маркер ашиглан тэмдэглэгээг хийнэ.
- Мэс засал хийх талбайд тухайн мэс заслын онцлогоос хамааран тохирох тэмдэглэгээг хийнэ.
- Талбайд тэмдэглэгээг хийхдээ “Х” тэмдэг тавихыг хориглоно.

- Тэмдэглэгээ талбайг ариутгаж, тусгаарласны дараа/ тусгаарлах даавуу тавьсны дараа/ харагдахуйц байна.

6.6 Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийн карт ба өвчний түүхэнд таних тэмдэглэгээ хийх

6.6.1 Амбулатори, тасгийн эмч нар өөрийн үйлчлүүлэгчийг хөгжлийн бэрхшээлтэйг /сонсголын, харааны, тулгуур эрхтний, сэтгэц мэдрэлийн гэх мэт/ танин тодруулна.

6.6.2 Үйлчлүүлэгч түүний асран хамгаалагчид таних тэмдгийг хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарлан зөвшөөрөл авна.

6.6.3 Байгууллагын батлагдсан загвар бүрийн таних тэмдгийг хэрэглэнэ. Таних тэмдэг нь 3x3 см хэмжээтэй байна.

6.6.4 Таних тэмдэглэгээг өвчний түүх, картын баруун дээд хэсэгт нааж хэрэглэнэ.


6.6.5 Тасаг албадын ахлагч нар таних тэмдэг, бугуйвчийн нөөцийг хангаж хэрэгжилтэнд хяналт тавина.

6.6.6 Эмч эмнэлгийн мэргэжилтнүүд бугуйвчийн өнгийн код, хөгжлийн бэрхшээлтэйг тэмдэглэсэн таних тэмдгийг таньж үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэглэж дадсан байна.

6.6.7 БОЭТ-ийн эмч сувилагч нар нь хэл яриа, сонсголын бэрхшээлтэй нь танигдсан үйлчлүүлэгчтэй бичгээр харилцах, боломжийг бүрдүүлсэн байх ба хэрэв үр дүнтэй харилцаа үүсгэх боломжгүй бол ЧХХ эмч, сувилагч, хөтөч дуудан тусламж авч болно.

6.6.8 Эмч эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн хоорондох аль төрлийн харилцаанд хэрэгтэй мэдээллийг орхигдуулалгүй хүргэх "ISBAR" аргачлалыг ашиглаж болно.


6.7 Үйлчлүүлэгчийг танин тодруулах зураглал



6.8 Танин тодруулах хүснэлт -1

Тэмдэглэгээний төрөл

| № | Ялган таних тэмдэг | Тайлбар | Хэрэглэх тасаг нэгж | Хаана байрлах |
|----|---|--|------------------------|-------------------------------|
| 1 |  | Унах эрсдэлтэй үйлчлүүлэгч | Эмнэлгийн бүх хэсэгт | Өрөөний хаалга, орны дэргэд |
| 2 |  | Харшил (эм тариа, хоол хүнс) | Эмнэлгийн бүх хэсэгт | Сувилагчийн пост |
| 3 |  | Хэцүү үйлчлүүлэгч | Эмнэлгийн бүх хэсэгт | Сувилагчийн пост |
| 4 |  | Сахиур | Хэвтэн эмчлүүлэх | Сувилагчийн пост |
| 5 |  | Халдвартай | Эмнэлгийн бүх хэсэгт | Сувилагчийн пост |
| 6 |  | Сонсголын бэрхшээлтэй | Эмнэлгийн бүх хэсэгт | Сувилагчийн пост |
| 7 |  | Харааны бэрхшээлтэй | Эмнэлгийн бүх хэсэгт | Сувилагчийн пост |
| 8 |  | Хэл ярианы бэрхшээлтэй | Эмнэлгийн бүх хэсэгт | Сувилагчийн пост |
| 9 |  | Тэргэнцэртэй | Эмнэлгийн бүх хэсэгт | Сувилагчийн пост |
| 10 |  | Хооллоход бэрхшээлтэй | Хэвтэн эмчлүүлэх тасаг | Сувилагчийн пост |
| 11 |  | Холголт цооролттой байрлал солихыг сануулсан сум | Хэвтэн эмчлүүлэх тасаг | Сувилагчийн пост |
| 12 |  | Хоол хорьсон | Хэвтэн эмчлүүлэх тасаг | Сувилагчийн пост, орны дэргэд |

| | | | | |
|----|---|---|------------------------|-------------------------------|
| 13 |  | Хиймэл шүдтэй | Хэвтэн эмчлүүлэх тасаг | Сувилагчийн пост, орны дэргэд |
| 14 |  | Сувилагчийн хяналтанд эм уух шаардлагатай | Хэвтэн эмчлүүлэх тасаг | Сувилагчийн пост |
| 15 |  | Чихрийн шижинтэй | Хэвтэн эмчлүүлэх тасаг | Сувилагчийн пост |
| 16 |  | Биеийн дулааны өөрчлөлттэй | Хэвтэн эмчлүүлэх тасаг | Сувилагчийн пост |
| 17 |  | Эрт сэрэмжүүлэх үнэлгээний оноо | Эмнэлгийн бүх хэсэгт | Сувилагчийн пост, орны дэргэд |

ДОЛОО:ҮР ДҮНТЭЙ ХАРИЛЦААГ БИЙ БОЛГОХ-IMPROVE EFFECTIVE COMMUNICATION

7.1 БОЭТөвөөр үйлчлүүлэгчийн яаралтай тусламжийн хуудас, түргэн тусламжийн хуудас, хяналтын карт, өвчтөний түүх зэрэг АШББ-т бүрэн гүйцэт товч тодорхой гаргацтай бичилт хийж үйлдлийг гардан гүйцэтгэгч баталгаажуулсан байна.

7.2 Үйлчлүүлэгчтэй үр дүнтэй харилцаа тогтоох дараах арга техникийг эмч эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагч бүр эзэмшсэн дадлагажсан байна.

- Угтан мэндлэх, инээмсэглэх
- Үйлчлүүлэгчийг суулгах, дотно уур амьсгал үүсгэж үзлэг, үйлчилгээг хийнэ
- Үйлчлүүлэгчийг сонсож түүнийгээ илэрхийлэх
- Үйлчлүүлэгчийн онцлогт үг хэллэгийг хэрэглэх
- Үйлчлүүлэгчийг магтах урамшуулах
- Үйлчлүүлэгчтэй тухайн үеийн сэтгэлийн хөдөлгөөнөөр харилцахгүй байх
- Өвчнийх нь талаар үзүүлэн таниулах материал ашиглан энгийн үгээр тайлбар хийх
- Шинжилгээний бэлтгэлийг бүрэн ойлгуулах
- Гэрээр хийх асаргаа эмчилгээг зааж, ойлгосон эсэхийг шалгах өөрөөр нь давтан хэлүүлэх
- Оношилгоо эмчилгээг зөвшөөрч байгаа эсэхийг асуух
- Хэзээ хяналтанд болон яаралтай үзүүлэхийг заавал зөвлөх

7.3 Үйлчлүүлэгчид илэрсэн өвчний аюултай шинжийг зөвлөсөн, хэзээ эргэн болон яаралтай үзүүлэх, яаралтай тохиолдолд хаашаа хандах зэрэг мэдээллийг заавал бичгээр өгч баталгаажуулсан байна.

7.4 Үйлчлүүлэгчдийн утасны захиалгыг /түргэн тусламжийн дуудлага, үзлэгийн дугаар захиалах/ бичиж тэмдэглэж мэдээллийг үйлчлүүлэгчээс давтан асууж баталгаажуулна.

7.5 Үйлчлүүлэгчийн бүх шинжилгээний хуудсанд лавлагаа үзүүлэлтийг заавал

оруулж хэвлэсэн байх ба лавлах үзүүлэлт өөрчлөгдсөн бол энэ талаар НЛТасгийн эрхлэгч мэдэгдэл хийж шинжилгээний хуудасны шинэ загварыг гарган ЭЭДЗахирлаар баталгаажуулан хэрэглэнэ.

7.6 Үйлчлүүлэгчийн амь насанд аюултай эсвэл эмчилгээнд шууд нөлөө үзүүлж болох хэвийн бус шинжилгээний үзүүлэлтийг АЮУЛТАЙ ХАРИУ гэнэ .

7.7 Яаралтай болон шинжилгээний аюултай өөрчлөлт илэрсэн шинжилгээг НЛ, ДОТ-ын шинжилгээг хянасан, хийсэн эмч, лаборант үйлчлүүлэгчийг уг шинжилгээнд илгээсэн тасаг амбулаторийн эмчид нэн даруй мэдээлэх бөгөөд үйлчлүүлэгч бусад эмнэлгээс ирж шинжилгээ өгсөн бол үйлчлүүлэгчийн бүртгэлтэй утсанд зурвас үлдээх, залгаж хэлэх зэрэг аргуудыг ашиглан мэдээллийг цаг алдалгүй хүргэнэ.

7.8 Мэдээлэгч нь яаралтай болон аюултай өөрчлөлт илэрсэн шинжилгээг мэдээлсэн талаар бүртгэл хөтлөн баталгаажуулна. Бүртгэлд өвчтөний овог нэр, регистр, шинжилгээ өгөлтийн код шинжилгээний хариу гарсан цаг минут, мэдээлсэн цаг минут, хэнд мэдээлсэн тухай баталгаажуулсан байна.

7.9 Амаар хэлсэн аюултай шинжилгээний үзүүлэлтийг сонсож хүлээн авч байгаа эмч бүрэн тэмдэглэн авах ба тэмдэглэсэн мэдээллийг эргүүлэн уншиж мэдээлэгч дахин баталгаажуулж хэвшсэн байна.

НАЙМ. АЮУЛТАЙ СЭРЭМЖЛҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭГ МЭДЭЭЛЛЭХ

8.1 ЗОРИЛГО: БОЭТ-ийн Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах нийтлэг журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд лабораторийн тасагт хийгдэж байгаа шинжилгээний хариу өвчтөний эмчилгээ болон амь насанд аюул учруулахаар хэт хазайж сэрэмжлүүлэх/аюултай хязгаарт хүрсэн үр дүнг эмчлэгч эмчид яаралтай мэдээлж анхааруулах сэрэмжлүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

8.2 Лабораторийн ажиллагсад болон эмнэлгийн эмч, сувилагч нар шинжилгээний үр дүнгийн сэрэмжлүүлэх/аюултай түвшинд хүрсэн тухай мэдлэгтэй байна.

8.3 Лабораторийн эмч, БАМ, лаборант нь шинжилгээг стандарт ажиллагааны дагуу зөв хийж шинжилгээний хариуны үнэн зөв байдлыг хангаж тус бүрийн үүрэгтэй оролцоно.

8.4 Аюултай хариу илэрсэн тохиолдолд лабораторийн эмчид мэдээлнэ, шинжилгээг давтан хийж, шалгана.

8.5 Давтан хийсэн шинжилгээ адилхан хариу гарсан тохиолдолд хэсэг хариуцсан технологич болон хэсэг хариуцсан эмчид мэдээлж, бүртгэнэ.

8.6 Аюултай хариуг мэдээлэх

- Лабораторийн эмч, технологич аюултай утгыг тогтоосон даруйдаа / Үр дүн бэлэн болсноос хойш 15 минутын дотор/ илгээсэн нэгж рүү утсаар мэдээллэн, холбогдож чадахгүй тохиолдолд өөрийн биеэр хэвлэмэл хариуг тасаг нэгжид хүргэж өгнө.

- Шинжилгээний үр дүнг мэдээлсний дагуу эмчлэгч эмч өвчтөний эмнэлзүйн шинжтэй холбон дүн шинжилгээг хийж шаардлагатай тохиолдолд тухайн шинжилгээг давтан, өвчтөнөөс дахин сорьц авч давтан шинжилнэ.

- Сэрэмжлүүлэх /аюултай хязгаарт хүрсэн шинжилгээний үр дүнг мэдээлсний дараа Хавсралт 2–д заасан "Шинжилгээний үр дүн сэрэмжлүүлэх/аюултай хязгаарт хүрснийг мэдээлэх бүртгэл"-д бүртгэнэ.

- Бүртгэлийн дараа эмнэлгийн мэдээллийн цахим системд хариуг оруулж, баталгаажуулна.
- Шинжилгээний үр дүн сэрэмжлүүлэх/аюултай хязгаарт хүрсэн тохиолдлын тайланг сар улирал жилээр гарган хянаж чанарын шалгуур үзүүлэлт болгоно.

8.7 Аюултай/ сэрэмжлүүлэх шинжилгээний утгын жагсаалт

- Цусны дэлгэрэнгүй шинжилгээ

Хүснэгт 2

| Үзүүлэлт | Нас | Хэвийн лавлах | Ихсэх | Багасах |
|----------------------------|-----------------|------------------------------|-------------------------|-------------------------|
| Гемоглобин/HGB | 0-6 сар | 11.0-16.0 g/dl | ≥19.0 g/dl | ≤8.0 g/dl |
| | 6 сар – 5нас | 11.0-15.0 g/dl | ≥17.0 g/dl | ≥8.0 g/dl |
| | 5 -17 нас | 11.0-15.0 g/dl | ≥17.0 g/dl | ≥7.0 g/dl |
| | Насанд хүрэгсэд | 11.0-16.0 g/dl | ≥19.0 g/dl | ≥5.0g/dl |
| Гематокрит/HCT | Бүх нас | 37-54% | ≥65 | ≤21% |
| Цагаан эс/WBC | Бүх нас | 4.0-10.0 x10 ⁹ /l | ≥30x10 ⁹ /l | ≤1.0x10 ⁹ /l |
| Ялтас эс/PLT | Бүх нас | 100-400 x10 ⁹ /l | ≥800x10 ⁹ /l | ≤50x10 ⁹ /l |
| Улаан эсийн тунах хурд/ESR | Бүх нас | 2-12 мм/ц | ≥70 мм/ц | - |

- Коагулограмм

| Үзүүлэлт | Нас | Хэвийн лавлах | Ихсэх | Багасах |
|------------|---------|---------------|------------|------------|
| APTT | Бүх нас | 26,1-36,3 сек | ≥85 сек | - |
| INR | Бүх нас | 0,8-1,2 сек | ≥3 сек | - |
| PT | Бүх нас | 10-14 сек | ≥35 сек | - |
| Фибриноген | Бүх нас | 200-400 мг/дл | ≥500 мг/дл | ≤100 мг/дл |
| Д-диамер | Бүх нас | <0,5 мг/л | >1,0 мг/л | |

APTT-/partial thromboplastin time/- зориуд идэвхижүүлсэн тромбопластины хугацаа

PT-протромбины хугацаа, INR/ international normalized ratio/

- Захын цусны түрхэцийн шинжилгээ

| Үзүүлэлт | Нас | Ихсэх | Багасах |
|----------|---------|---------------------|---------|
| Бласт | Бүх нас | >5% | - |
| Шистоцит | Бүх нас | Их хэмжээгээр илрэх | - |

- **Иммуногематологийн шинжилгээ**

| Үзүүлэлт | Нас | Хэвийн лавлах | Аюултай/сэрэмжлүүлэх үр дүн |
|-----------------------------|---------|---------------|-----------------------------|
| Цусны бүлэг, хувийн тохироо | Бүх нас | Тохирсон | Тохироогүй |

- **Биохимийн шинжилгээ**

| Үзүүлэлт | Нас | Хэвийн лавлах | Ихсэх | Багасах |
|----------------|--------------|-------------------|----------------|--------------|
| АЛАТ | Бүх нас | 0.0-45.0 u/l | ≥1000 u/l | - |
| АСАТ | Бүх нас | 0.0-35.0 u/l | ≥1000 u/l | - |
| Нийт билирубин | Бүх нас | 1.7-21.0мк/моль/л | ≥300 мк/моль/л | - |
| Шууд билирубин | Бүх нас | 0.0-6.8 мк/моль/л | ≥100 мк/моль/л | |
| Амилаза | Бүх нас | 0.0-100.0 u/l | ≥ 600 г/л | |
| Сахар | Бүх нас | 3.0-6.4 ммоль/л | ≥18 ммоль/л | ≤2.5 ммоль/л |
| ЛДГ | Бүх нас | 0.0-247 u/l | ≥1000 u/l | - |
| Креатинин | Бүх нас /эр/ | 80-115 мк/моль/л | ≥1500мк/моль/л | - |
| | Бүх нас /эм/ | 53-97 мк/моль/л | ≥1500мк/моль/л | |
| Мочевин | Бүх нас | 2.6-7.3 ммоль/л | ≥30 ммоль/л | - |
| Натри | Бүх нас | 135-155 ммоль/л | >165 ммоль/л | <120 ммоль/л |

| | | | | |
|------|---------|-----------------|--------------|--------------|
| Кали | Бүх нас | 3.5-5.1 ммоль/л | >5,5 ммоль/л | <2,5 ммоль/л |
| CRP | Бүх нас | 0.0-5.0 мг/л | ≥ 100 мг/л | |

- **Иммунологи/серологийн шинжилгээ**

| Үзүүлэлт | Хэвийн лавлах | Аюултай/сэрэмжлүүлэх үр дүн |
|---------------------------------|-----------------|-----------------------------|
| Хэт мэдрэг тропнин Hs-cTnl | 0.0-0.040 ng/ml | >0.10 ng/ml |
| Тропинин cTnl | 0.0-0.10 ng/mL | >1.5 ng/mL |
| Натри хөөгч пептид NT-proBNP | 0.0-300.0 pg/ml | 35000 pg/ml |
| Прокальцитонин PCT | 0.0-0.10 ng/mL | 50.0 ng/mL |
| ДОХ шинжилгээ | сөрөг | Эерэг |

- **Клиник химийн шинжилгээ**

| Үзүүлэлт | Хэвийн лавлах | Аюултай/сэрэмжлүүлэх үр дүн |
|---------------|---------------|-----------------------------|
| Шээсний уураг | 0.0-0.033 г/л | 1.65 г/л |
| ТНШ цагаан эс | - | Их |
| ТНШ улаан эс | - | |

- **Нян судлалын шинжилгээ**

| Хэвийн лавлах | Аюултай/сэрэмжлүүлэх үр дүн |
|-------------------|--|
| Нянгийн ургалтгүй | Carbapenem-Resistant Enterobacteriaceae (CRE) |
| | Methicillin-resistant Staphylococcus aureus (MRSA) |
| | Vancomycin-Resistant Enterococcus (VRE) |
| | Extended Spectrum Beta-Lactamase (ESBL) |

| | |
|--|----------------------------|
| | Acinetobacter baumannii |
| | Pseudomonas Aeruginosa |
| | Neisseria meningitides |
| | Streptococcus pyogenes |
| | Salmonella spp |
| | Shigella spp |
| | Esherichia coli 0157 |
| | Mycobacterium tuberculosis |


- **Молекул биологийн шинжилгээ**

| Үзүүлэлт | Нас | Хэвийн лавлах | Аюултай/сэрэмжлүүлэх үр дүн |
|-------------|---------|---------------|-----------------------------|
| Sars-Covid2 | Бүх нас | сөрөг | ээрэг |
| Flu-A | Бүх нас | сөрөг | ээрэг |
| Flu-B | Бүх нас | сөрөг | ээрэг |

8.8 Шинжилгээний үр дүн сэрэмжлүүлэх/аюултай хязгаарт хүрснийг мэдээлэх бүртгэл

| Аюултай шинжилгээ мэдээллэх загвар | | | | | | | | | | | Мэдээлэгдээгүй аюултай хариу | | |
|------------------------------------|--------------------|-----------|----------------|------------------------------------|---------------|--------------------------------|--------|-----------------------------------|---------------------------------------|---|------------------------------|-------------|------------|
| Он сар өдөр | Өвчтөний овог, нэр | Нас, хүйс | Илгээсэн тасаг | Хязгаараас хэтэрсэн элементийн нэр | Хүрсэн хэмжээ | Дахин сорьц авч шинжилсэн эсэх | Үр дүн | Мэдээллийг хүлээн авсан хүний нэр | Мэдээлсэн хариуг буцааж асуусан тухай | Мэдээлсэн лабораторийн ажилтны гарын үсэг | Шалтгаан | Арга хэмжээ | Гарын үсэг |
| | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | |

ҮР ДҮНТЭЙ ХАРИЛЦАА БИЙ БОЛГОХ, АЮУЛТАЙ СЭРЭМЖЛҮҮЛЭХ ХАРИУ МЭДЭЭЛЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗУРАГЛАЛ



8.9 Радиологын шинжилгээний нэн ноцтой өөрчлөлтийг мэдээлэх

8.9.1 Дүрс оношилгооны яаралтай болон санаандгүй ололтын жагсаалтанд багтсан өөрчлөлтүүдийг дүгнэхэд тусгайлан тэмдэглэх үүрэгтэй байна. Үүнийг ахлах дүрс оношилгооны эмч нар эсвэл тусгайлан үүрэг заасан техникч нар гүйцэтгэнэ.

8.9.2 Дүрслэлийн шинжилгээ гүйцэтгэхээс мэдээллэх хүртэлх хугацаа нь нэг цаг байх бөгөөд энэхүү хугацаанд илгээсэн/ эмчлэгч эмч буюу харьяалагдах тусламж үйлчилгээний тасаг нэгжийг жижүүр эмчид мэдээлж, мэдээлсэн эсэхийг бичгээр баримтжуулсан байна.

8.9.3 Мэдээллэх дараалал:

- Шинжилгээний заалт гаргасан эмчлэгч эмч рүү утсаар хэлэх
- 15 минутын дараа ямарч хариу байхгүй бол дахин залгана.
- 30 минутын дараа ямарч хариу байхгүй бол шинжилгээ рүү илгээсэн тасаг нэгжийн жижүүр эмч эсвэл сувилагчийн пост дээр байгаа сувилагчаар дамжуулан харьяалагдах тасгийн эмчлэгч эмч нарт мэдээлнэ.
- Эмчлэгч эмч тодорхойгүй, амбулаторийн захиалгаар хийгдсэн шинжлүүлэгч бол амбулаторийн эрхлэгч ба яаралтай тусламжийн тасгийн жижүүр эмчид мэдээлнэ.
- Хэнд, хэрхэн мэдээлсэнээ дүрслэлийн шинжилгээний дүгнэлтэнд тодорхой бичиж тэмдэглэнэ.

8.9.4 Хариу гаргах:

- Мэдээллэх үед ноцтой өөрчлөлтийн талаар товч аман байдлаар мэдээлнэ.
- Бичгийн хариуг мэдээлсэнээс хойш 2 цагийн дотор дүрс оношилгооны эмч гаргана.
- Яаралтай гаргасан хариуг мэргэшсэн дүрс оношилгооны эмч нягталж, ердийн

журамд хариу гаргахаар заагдсан хугацааны дотор баталгаажуулна.

8.9.5 Дүрс оношилгооны яаралтай болон санаандгүй ололтын жагсаалтанд багтсан өөрчлөлтүүдийг дараах жагсаалтанд дурдсан

Хүснэгт 3

| Анатомын хэсэг | Яаралтай байдлууд | Дүрслэлийн шинжилгээ |
|----------------|--|----------------------|
| Бүх хэсэг | Мэс заслын хэрэгсэл үлдээх | КТ,Рентген |
| | Тавигдсан гуурс, хэрэгслүүд эмгэг байрлал орсон байх/ төвийн гуурс, хамар-залгиурын зонд гм/ | Рентген,КТ,СРТ, Эхо |
| | Шинээр оношлогдож буй гавал доторхи цусан хураа | КТ,СРТ |
| | Том хэмжээний цасан хангамжийн савыг хамарсан тархины шигдээс | КТ,СРТ |

| | | |
|-------------------------|---|--------------------------------------|
| Төв мэдрэлийн тогтолцоо | Шинээр оношлогдож буй том судасны бөглөрөл | Рентген,КТ,СРТ |
| | Хүзүүний нурууны болон гавлын хугарлууд | Рентген,КТ,СРТ |
| | Нугас шахагдсан байх/ хугарал, эзэлхүүнт өөрчлөлтүүд гэх мэт/ | Рентген,КТ,СРТ |
| | Гавал доторхи хөндийд агаар илрэх | Рентген,КТ,СРТ |
| Хүзүү | Амьсгалын зам нарийссан байх/ /жишээлбэл эпиглотит/ | Рентген,КТ,СРТ |
| | Гүрээний судасны диссекци | КТ,СРТ |
| | Гүрээний тараагуур судасын ноцтой нарийсал | КТ,СРТ |
| Цээж | Шинээр оношлогдож буй пневмоторакс | Рентген,КТ |
| | Чинэрсэн буюу том хэмжээний / уушгины талбайн 3/1-ээс их/ пневмоторакс илрэх | Рентген,КТ |
| | Пневмомедиастениум, пневмоперикарди илрэх | Рентген,КТ |
| | Уушигны артерийн бөглөрөл | Рентген,КТ |
| | Гол судасны диссекци, гол судасны цуурал, гол судасны цус алдалтууд | Рентген,КТ |
| | Шинээр оношилогдож буй гемоторакс гемоперикарди | Тодосгогчтой рентген, КТ, СРТ, Ангио |
| Хэвлий | Шинээр үүссэн пневмоперитонеум | Рентген, КТ, эхо |
| | Тодосгогч бодис гадагшилах / хөндийд эрхтэнүүдээс шүүрэх, судаснаас алдах гм/ | Рентген,КТ,СРТ |
| | Үүндэн венд агаар илрэх | КТ,СРТ, эхо |
| | Том судасны бөглөрөлт: хураагуур болон тараагуур | |
| | Гемоперитонеум | КТ, Эхо |
| | Цуллаг эрхтний гэмтэл, няцрал | КТ, Эхо |
| | Цочмог мухар олгойн үрэвсэл | КТ, Эхо |

| | | |
|-------------|--|---------|
| | Гэдэсний цус хомсрол, боймлогдох, чихэлдэх | КТ, Эхо |
| | Хэвлийн арын зайн цус алдалт | КТ, Эхо |
| Бага аарцаг | Умайн гадуурх жирэмслэлт хагарах | КТ, Эхо |
| | Жирэмсний сүүлийн гурван сард эхэс түрүүлэлт шинэ цус алдалттай давхацах | КТ, Эхо |
| | Цус алдалтаар хүндэрсэн өндгөвчийн уйланхай / өндгөвчийн апоплекси/ | КТ, Эхо |
| | Эхэс ховхрох | КТ, Эхо |
| | Өндгөвч сууриар эргэх | КТ, Эхо |
| | Төмсөг сууриар эргэх | КТ, Эхо |

ЕС: УНАХ ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

9.1 Зорилго: Үйлчлүүлэгчдийн явганаас унах эрсдэлийг үнэлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, эрсдэлээс үүсэх бэртэх гэмтэхээс сэргийлэхэд оршино. /ICD/-д W00-W19 оношинд хамрагдах бөгөөд ухаан алдаж унах, муужрах эсвэл эпилепси өвчний улмаас татаж унах энэхүү ойлголтод хамаарахгүй.

9.2 Эмчлүүлэгчийн унах эрсдэлийн түвшин олон улсын үнэлгээний аргаар тодорхойлж, үнэлгээнд тулгуурлан зохих журмын дагуу арга хэмжээг авч, урьдчилан сэргийлэх бөгөөд хүүхдийг Хампти Дампийн үнэлгээгээр, насанд хүрэгчдийг Морсийн үнэлгээгээр тус тус үнэлнэ.

9.3 Үнэлгээг дараах тасаг нэгжүүдэд хэрэглэнэ. Үүнд:

- Хэвтэн эмчлүүлэх бүх тасаг
- Амбулатори, Дүрс оношилгоо, яаралтай тусламжийн тасагт шаардлагатай тохиолдолд

9.4 Сувилагч эмчлүүлэгчийг унах эрсдэлтэй эсэхийг тодорхойлно. Үүнд:

- Хэвтэн эмчлүүлэх тасгуудад эмчлүүлэгчийг анх хүлээн авсан тухайн ээлжийн

сувилагч үнэлж, үнэлгээг хийхдээ өөрчлөх боломжгүй хүчин зүйлийг харгалзан унах, эрсдэлийг тодорхойлно. Үүнд:

- 0-3 насны хүүхдийг “Эрсдэлтэй” гэж үнэлэх
- 15 насны хүүхдийг “Хүүхдийн унах эрсдэлийн үнэлгээ” буюу Хампти Дамптийн

үнэлгээгээр

- 16 наснаас дээш хүмүүсийг “Насанд хүрэгчдийн унах эрсдэлийн үнэлгээ” буюу

Морсийн үнэлгээгээр

- 65-с дээш насны хүмүүс “Эрсдэлтэй” гэж үнэлэх

9.5 Үнэлсэн үнэлгээний хуудсыг сувилгааны түүхэнд хавсарган сувилахуйн

тэмдэглэл хөтөлж, үйлчлүүлэгчийн эрсдэлийн онооноос хамаарч доорх давтамжаар хяналтын хуудас хөтөлнө. Үүнд:

- 0-3 насны хүүхэд “Эрсдэлтэй” ангиллын эмчлүүлэгчийг 6цаг тутам
- 12-с доош үнэлгээтэй 4-15 насны хүүхдийг 8 цаг тутамд
- 25-аас дээш үнэлгээтэй 16 наснаас дээш хүмүүсийг 8 цаг тутам

9.6 Унах эрсдэлтэй гэж үнэлэгдсэн хүмүүст урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Унах эрсдэлтэй эмчлүүлэгчийг шар өнгийн бугуйвч зүүнэ.
- Унах эрсдэлтэй эмчлүүлэгчид ялгах танин шар “навч” тэмдгийг дараах байршилд байрлуулж, ээлж хүлээлцэх бүрд мэдээллийг тодорхой солилцоно. Үүнд:
 - Өвчтөний түүхийн нүүр хэсэгт
 - Өрөөний хаалга
 - Орны дэргэд

9.7 Эрсдэл багатай гэж үнэлэгдсэн боловч дараах тохиолдлуудад унах эрсдэлийн үнэлгээг дахин хийнэ:

- Зөөвөрлөх үед
- Эмнэлгээс түр гарч, дахин хэвтэх үед
- Унах эрсдэл хүргэж болзошгүй эм, эмийн бодис хэрэглэж байгаа бол /сэтгэл гутрал болон сэтгэл уналтын эсрэг, сэтгэц нөлөөт мансууруулах, тайвшруулах унтуулах, таталтын эсрэг, даралт бууруулах болон шээс хөөх, харшлын эм, эмийн бодис/
- Тайвшруулалтай шинжилгээ, эмчилгээ хийлгэх үед, хийлгэсний дараа /дуран, биед нөлөөгүй инвазив ажилбар, өдрийн хагалгаа/
- Эмчлүүлэгч 24 цагийн дотор хэсгийн мэдээ алдуулалтай ажилбар хийлгэсэн, эмийн хэрэглээ нэмэгдсэн тохиолдолд
- Эрсдэлгүй гэж үнэлэгдсэн, дээрх хүчин зүйлсийн нөлөөлөлгүй эмчлүүлэгчийг 3 дахь хоног тутамд
- Хөдөлгөөн засал болон бусад сэргээн засах эмчилгээ хийлгэсэн үйлчлүүлэгчид

9.8 Өрөө, тасгийн шал хуурай, шалан дээр хөлд тээглэх зүйл байгаа эсэхийг анхаарч, шал нойтон, тээглэх саадтай байвал шалыг арчуулна.

9.9 Үйлчлүүлэгч шал угааж байгаа тохиолдолд “халтирч унахаас болгоомжил” анхааруулах тэмдэглэгээ байрлуулна.



Зураг 1. Халтирч унах эрсдэл заасан тэмдэг

9.10 Эмчлүүлэгч орон дээрээ байгаа тохиолдолд орны хаалтыг байнга өндөрлөдөг.

9.11 Угаалгын өрөө болон бие засах өрөөнд түших, дэмжлэг авах бариул байрлуулах, гэрэлтүүлэг хангалттай эсэхийг шалгана.

9.12 Унах эрсдэлтэй эмчлүүлэгчийг эмчилгээ, оношилгоо хийлгэх явцад тэргэнцрээр зөөвөрлөх ба сувилагч, эмнэлгийн ажилчид “гараас гарт” зарчмыг баримтална.

9.13 Эмчлүүлэгчийн ор, тэргэнцэр, шинжилгээний хөдөлгөөнт орны дугуйг түгжинэ.

9.14 Зөөвөрлөж байгаа эмчлүүлэгчийг цахилгаан шат уруу оруулах болон гарах үед цахилгаан шат шалтай нэг түвшинд байгаа эсэхийг шалгаад ухарч орно.

9.15 Гадаад болон дотоод орчны үнэлгээг дараах алба нэгж, албан тушаалтнууд хариуцан хийнэ. Үүнд:

- Гадаад орчинд ХАБЭА мэргэжилтэн, аж ахуйн алба үнэлгээ хийж сайжруулалтыг тогтмол хийнэ.
- Дотоод орчинд тухайн тасаг, нэгжийн чанарын багийн гишүүд, эрсдэлийн менежерүүд / тасгийн эрхлэгч, ахлах сувилагч/ байршлыг тогтоож, үнэлгээ хийж, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангаж ажиллана.

9.9.1 Эмнэлгийн ажилтан бүр эмнэлгийн орчинд унасан тохиолдлыг мэдсэн даруй “тохиолдол мэдээлэх” зураглалын дагуу чанарын албанд мэдээлнэ.

Хүүхдийн унах эрсдэлийг Хампти Дамптийн үнэлгээ

| Эмчлүүлэгчийг овог,нэр | Нас, хүйс: | Өвчний түүх№. |
|--|---|----------------------------|
| Үзүүлэлт | Шалгуур | Оноо |
| Нас | 3 хүртэлх | <input type="checkbox"/> 4 |
| | 3-7 нас | <input type="checkbox"/> 3 |
| | 7-13 нас | <input type="checkbox"/> 2 |
| | 13 ба түүнээс дээш нас | <input type="checkbox"/> 1 |
| Хүйс | Эрэгтэй | <input type="checkbox"/> 2 |
| | Эмэгтэй | <input type="checkbox"/> 1 |
| Онош | Мэдрэлийн | <input type="checkbox"/> 4 |
| | Хүчилтөрөгчийн өөрчлөлт / амьсгалын замын онош , шингэний дутагдал, цус багадалт, хоолны дуршил буурах , ухаан балартах, толгой эргэх / | <input type="checkbox"/> 3 |
| | Сэтгэц зан төрөхийн эмгэг | <input type="checkbox"/> 2 |
| | Бусад онош | <input type="checkbox"/> 1 |
| Танин мэдэхүйн өөрчлөлт | Танин мэдэхүйн өөрчлөлттэй | <input type="checkbox"/> 3 |
| | Мартамхай | <input type="checkbox"/> 2 |
| | Хэвийн | <input type="checkbox"/> 1 |
| Орчны хүчин зүйлс | Унаж бэртэж байсан, эсвэл зөөврийн ор хүүхдийн тэрэг ашиглаж байгаа | <input type="checkbox"/> 4 |
| | Туслах хэрэгсэл хэрэглэдэг | <input type="checkbox"/> 3 |
| | Эмчлүүлэгч орон дээр байгаа | <input type="checkbox"/> 2 |
| | Амбулаторийн хэсэгт байгаа | <input type="checkbox"/> 1 |
| Мэс ажилбар ба тайвшруулалт мэдээгүйжүүлэг | 24цаг дотор | <input type="checkbox"/> 3 |
| | 48 цаг дотор | <input type="checkbox"/> 2 |
| | 8 цагаас дээш | <input type="checkbox"/> 1 |

| | | |
|--|---|----------------------------|
| Эмийн хэрэглээ | Тайвшруулах эм / сэтгэц нөлөөт эм, шээс хөөх эм ба туулгах эм,нойрсуулах эм, сэтгэл хөөрлийн эсрэг эм, сэтгэл гутралын эсрэг эм, таталтын эм/ | <input type="checkbox"/> 3 |
| | Дээрх эмүүдийн нэгийг хэрэглэж байгаа | <input type="checkbox"/> 2 |
| | Бусад эм эсвэл үгүй | <input type="checkbox"/> 1 |
| Нийт оноо | | |
| Унах эрсдэлийн өөрчлөх боломжгүй хүчин зүйл | | |
| <ul style="list-style-type: none"> ○ Яаралтай тусламжийн хэсгээр үйлчлүүлэгч ○ Нярайн болон нярайн сэхээн амьдруулах тасагт эмчлүүлэгч | | |

.....
 Өөрчлөх боломжгүй эрсдэлд байгаа эмчлүүлэгчдийг үнэлгээний оноог харгалзахгүй унах эрсдэлтэй бүлэгт хамааруулна.

*** Эмнэлэгт хэвтсэн өдөр, эмнэлэгт хэвтсэнээс хойш 3 дах хоногт, хагалгааны дараа мэс заслын тасагт, урт хугацааны эмчилгээний тохиолдолд 7 хоног тутамд үнэлнэ.

Сувилагчийн нэр:огноо, Цаг.....

Ахлаг сувилагчийн нэр:.....огноо, цаг.....

НАСАНД ХҮРЭГЧДИЙН УНАХ ЭРСДЭЛИЙГ МОРСИЙН ҮНЭЛГЭЭ

Эмчлүүлэгчийг овог, нэр

Нас, хүйс:

Өвчний түүх№

| Үзүүлэлт | Шалгуур | Үнэлгээ |
|---|--|---------|
| Сүүлийн 3 сарын дотор унаж байсан эсэх | Үгүй | 0 |
| | Тийм | 25 |
| 2 ба түүнээс дээг өвчний оноштой эсэх | Үгүй | 0 |
| | Тийм | 15 |
| Туслах хэрэгсэл ашигладаг эсэх | Үгүй /хэвтрийн дэглэмтэй/ | 0 |
| | Суга таяг/алхагч | 15 |
| Судсаар эмчилгээ хийлгэж байгаа эсэх | Үгүй | 0 |
| | Тийм | 20 |
| Алхах чадвартай эсэх | Хэвийн /хэвтрийн дэглэмтэй/ | 0 |
| | Чадваргүй /саажилтай | 20 |
| Ухаан санааны байдал | Хэвийн | 0 |
| | Танин мэдэхүйн өөрчлөлттэй | 15 |
| Эрсдэлийн түвшин | Бага эрсдэлтэй 0-24 оноо | |
| | Дунд эрсдэлтэй 25-50 | |
| | Өндөр эрсдэлтэй 51 | |
| _Нийт оноо | | |
| Унах өндөр эрсдэлийн өөрчлөх боломжгүй хүчин зүйлс | | |
| Эмчлүүлэгчийн биеийн байдалтай холбоотой эрсдэлт хүчин зүйл | <ul style="list-style-type: none"> ○ Сэтгэл хөөрөлтэй ○ Нойр бэрхшээлтэй ○ Шээхэд бэрхшээлтэй ○ Толгой эргэх, байрлалаас хамаарсан даралт багадалттай ○ Хараа , сонсгол муудалтай | |
| Эмтэй холбоотой эрсдэлт хүчин зүйл | <ul style="list-style-type: none"> ○ Сэтгэл гутралын эсрэг ○ Мансууруулах эмүүд ○ Унтуулгын эмүүд ○ Сэтгэл уналтын эсрэг ○ Нойрсуулах эмүүд ○ Саажилтын эсрэг | |

| | |
|--------------------------|--|
| | <input type="radio"/> Сэтгэц нөлөөт <input type="radio"/> Шээс хөөх <input type="radio"/> Даралт бууруулах |
| Бусад эрсдэлт хүчин зүйл | <input type="radio"/> Яаралтай тусламжийн тасагт байгаа <input type="radio"/> 65 ба түүнээс дээш настай |

*** Өөрчлөх боломжгүй эрсдэлд байгаа эмчлүүлэгчдийг үнэлгээний оноог харгалзахгүй унах эрсдэлтэй бүлэгт хамааруулна.

*** Эмнэлэгт хэвтсэн өдөр, эмнэлэгт хэвтсэнээс хойш 3 дах хоногт, хагалгааны дараа мэс заслын тасагт, урт хугацааны эмчилгээний тохиолдолд 7 хоног тутамд үнэлнэ.

Сувилагчийн нэр:

Цаг.....

Ахлаг сувилагчийн нэр:.....огноо, цаг.....

УНАЖ БЭРТЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Эмчлүүлэгчийг овог, нэр

Нас, хүйс:

Өвчний түүх№

| № | Огноо | | | | | | | | | | | | | | | | | | |
|------------------------------------|---|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| Унах эрсдэлийн үнэлгээ хийсэн цаг | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Унах эрсдэлийн үнэлгээ хийсэн оноо | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Таних тэмдэг зүүж өгөх | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Эмчлүүлэгчийн өрөөний гадна талд анхааруулах тэмдэглэгээ байрлуулах | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Байрлал солих болон бие засах зэрэг шаардлагатай тохиолдолд тусламж дуудах зааварчилгаа өгөх. | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Эмчлүүлэгчийн байнга хэрэглэдэг зүйлсийг гарт нь ойр байлгах | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | Шал нойтон үед арчиж цэвэрлэх | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Орчны гэрэлтүүлгийг хангалттай байлгах | | | | | | | | | | | | | | | | | | |
| 7 | Эмчлүүлэгч орон дээр байгаа үед орны хашлагыг өндөрлөх | | | | | | | | | | | | | | | | | | |
| 8 | Орны өндөр намыг байнга тохируулах, доор байлгах | | | | | | | | | | | | | | | | | | |
| 9 | Өргөхөд зориулсан бүс, түнх хамгаалагч зэргээр хангах | | | | | | | | | | | | | | | | | | |
| 10 | Тусламж үйлчилгээг гараас гарт гэсэн зарчмаар явуулах | | | | | | | | | | | | | | | | | | |
| 11 | Хөлд эвтэйхэн, халтирдаггүй ултай гутал өмсөх | | | | | | | | | | | | | | | | | | |
| 12 | Шалан дээр хөлд тээглэх зүйл байгаа эсэхийг анхаарах | | | | | | | | | | | | | | | | | | |
| 13 | Эмчлүүлэгчийн орны дэргэд зөөлөвч, гудас байрлуулах | | | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | |
|------------------|---|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| 14 | Эмчлүүлэгч болон тэдний ар гэрт унахаас сэргийлэх арга хэмжээг тайлбарлан хамтран ажиллах | | | | | | | | | | | | | | | | | | |
| Хянасан сувилагч | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Ахлах сувилагч | | | | | | | | | | | | | | | | | | | |

****0-3 насны хүүхэд, 65-аас дээш насны “Эрсдэлтэй” ангиллын эмчлүүлэгчийг байнгын хяналтаар Эмчлүүлэгч унах эрсдэлтэй бол хяналтын хуудсыг тогтмол 8 цаг тутамд тус тус хөтөлнө.*

ОРЧНЫ УНАХ ЭРСДЭЛ ҮНЭЛЭХ ХУУДАС ХЯНАХ САЙЖРУУЛАХ

Гадаад дотоод ээлтэй орчны үнэлгээ

| № | | Орчны үнэлгээний үзүүлэлтүүд | Оноо | Авсан оноо | Нэмэлт мэдээлэл |
|----------------|---------------------------|--|------|---------------|--------------------|
| 1. Гадна орчин | | | | | |
| 1 | Байгууллагын хаяг | -Харагдахуйц хэмжээтэй тод -Харах түвшинд нүдэнд тусахаар газар байрлуулсан. -Агуулгын хувьд ойлгомжтой -Өнгө үзэмжтэй | 5 | | |
| 2 | Явган хүний зам | -Тэгш гадаргатай -Хальтаргаа гулгаагүй -Хашлага бариултай -Шаардлагатай хэсэгт байрласан | 5 | | |
| 3 | Гадна шат довжооны бариул | -Тогтвортой -Өнгө үзэмжтэй -Хальтаргаа гулгаагүй -Шатны гишгэх талбай хүрэлцээтэй -Шатны ирмэг бүтэн -Шатны өндөр өргөн ижил хэмжээтэй -Бариулын өндөр, урт шаардлага хангасан | 5 | | |
| 4 | Орох хаалга | -Стандарт өндөр өргөнтэй -Өнгө үзэмжтэй -Бариултай -Босгогүй | 5 | | |
| 5 | Тэргэнцэрийн зам | -Налуу өндөртэй стандартын дагуу хийгдсэн. | 6 | | |

| | | | | | |
|------------------------|-------------------------|--|---|--|--|
| | | -Өнгө үзэмжтэй -Бариултай -Хальтиргаа гулгаагүй -Эргэх талбай хангалттай | | | |
| 6 | Сүүдрэвчтэй эсэх | -Өнгө үзэмжтэй -Цэвэр орчинтой -Ширээ сандалтай -Тоо хэмжээ хангалттай | 6 | | |
| 7 | Ногоон байгууламж | -Өнгө үзэмжтэй -Цэвэр орчинтой -Мод, бут, зүлэг -Ногоон байгууламжийн хэмжээ хангалттай | 6 | | |
| 8 | Гадна гэрэлтүүлэг | -Гэрэлтүүлэг хангалттай тод -Аюулгүй -Өнгө үзэмжтэй -Шаардлагатай талбайд байрласан. | 6 | | |
| 2. Дотоод орчин | | | | | |
| 1 | Шатны гишгүүрийн байдал | -Стандарт өндөртэй -Өнгөөр ялгасан. -Тогтвортой, аюулгүй -Бариултай -Ирмэг бүтэн | 6 | | |
| 2 | Шал дэвсгэрийн байдал | -Зориулалтын эдээр хийсэн. -Эрүүл ахуйн шаардлага хангасан | 6 | | |

| | | | | | |
|---|---|--|---|--|--|
| | | -Хальтиргаа гулгаагүй -Тэгш гадаргатай -цэвэр | | | |
| 3 | Коридор ба өрөөний гэрэлтүүлэг | -Коридорын гэрэлтүүлэг тод -Өрөөний гэрэлтүүлэг тод -Өрөө бүр хажуугийн гэрэлтүүлэгтэй -Гэрэлтүүлэг аюулгүй -Унтраалга зөв газар байрласан | 5 | | |
| 4 | Коридор ба өрөөний агааржуулалт, дулаан чийглэг | -Коридор агааржуулалттай -Өрөөнүүд агааржуулалттай -Элдэв үнэргүй -Дулаан хэмжигчтэй -Чийг хэмжигчтэй | 5 | | |
| 5 | Өрөөний нэр хаяг | -Харагдахуйц газар байрлуулсан -Тод томоор бичсэн -Ойлгомжтой -Өнгө үзэмжтэй | 6 | | |
| 6 | Ажилтны танилцуулга, цагийн хуваарь | -Харагдахуйц байрлалтай -Ойлгомжтой -Өнгө үзэмжтэй | 5 | | |
| 7 | Мэдээллийн самбарын харагдах байдал | -Харагдахуйц тод бичигдсэн -Ойлгомжтой -Хэрэгцээтэй -Өнгө үзэмжтэй | 5 | | |
| 8 | Коридорын хүлээлгийн сандлын байдал | -Түшлэгтэй -Стандарт өндөртэй -Ая тухтай байдлыг хангасан. | 6 | | |

| | | | | | |
|-----------|---|---|-----|--|--|
| | | -Өнгө үзэмжтэй | | | |
| 9 | Тэргэнцэртэй эсэх | -Настанд тохирсон хэмжээтэй -Хэрэглэхэд бэлэн ойр -Аюулгүй байдал хангасан. -Цэвэр | 6 | | |
| 10 | Ариун цэврийн өрөөний тохижилтын байдал | -Настанд тохирсон суултууртай -Дотроо тулж босох бариултай -Түгжээтэй -Эрүүл ахуйн шаардлага хангасан -Өрөөний талбайн стандарт хангасан байдал /2х3мкв-аас багагүй | 6 | | |
| Нийт оноо | | | 100 | | |

АРАВ: ӨНДӨР ЭРСДЭЛТ ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ, ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

10.1 Тус эмнэлэгт үйлчлүүлэгчдэд өндөр эрсдэл эмийн жор бичих, эмчилгээнд хэрэглэх, эмчилгээний хяналт хийх болон эмээс шалтгаалах эрсдэлээс сэргийлэх, авах арга хэмжээг зохицуулж, эмийн аюулгүй байдлыг сайжруулах зорилготой

10.2 Нэр томъёо:

- **Өндөр эрсдэлтэй эм** гэж эмийн эмчилгээний алдаа үүссэн тохиолдолд эмчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд сөрөг үр дагавар үзүүлэх буюу эмийн гаж нөлөө үүсгэх эрсдэлт өндөртэй эмийг хэлнэ.

- **Адил дуудагддаг, адил харагддаг эм** гэж эмийн анхдагч болон хоёрдогч савлагааны харагдах байдал болон эмийн олон улсын ба худалдааны нэршил төстэй учраас андуурагдах эрсдэлтэй эмийг хэлэх бөгөөд өндөр эрсдэлт эмэд хамруулж үзнэ.

- **Эмийн эмчилгээний алдаа** гэж эмийн эмчилгээнд хэрэглэх явцад эмчлүүлэгчийн эрүүл мэндэд хохирол /бие махбодын бүтэц, үйл ажиллагааны болон сэтгэл санааны/ үүсгэсэн болон үүсэж болзошгүй алдааг хэлнэ.

10.3 Өндөр эрсдэл эмийн захиалга бэлтгэх, хадгалах

10.3.1 Эмнэлгийн өндөр эрсдэлт эмийн жагсаалтыг эмнэлгийн эмийн эмчилгээний хороо баталж, эмийн жагсаалтад өөрчлөлт оруулах үед хамтад нь шинэчилнэ.

10.3.2 Өндөр эрсдэлт эмийн бүлэгт дараах бүлгийн эмийн хамруулна:

- Судас идэвхт эм (Vasoactive)
- Антикоагулянт
- Өндөр концентрацитай электролитийн уусмал
- Инсулин

- Мансууруулах, сэтгэц нөлөөт эм
- Мэдрэл-булчинг хориглогч /Neuromuscular blocking agent/
- Хэсэг газрын мэдээ алдуулах эм
- Хими эмчилгээний эмүүд
- Адил дуудагддаг, адил харагддаг эм

10.3.3 Өндөр эрсдэл, адил дуудагддаг, адил харагддаг эмүүдэд утсаар болон аман захиалга хийхгүй.

10.3.4 Өндөр эрсдэлт эмийн жагсаалтад хадгалалтын тусгай горим шаардлагатай болон эмийн нөөцтэй тасаг нэгж, тэргэнцрийн байршлыг тэмдэглэсэн байна.

10.3.5 Эм зүйн албанд өндөрт эрсдэлт эмийн жор бэлтгэх үйл явцад дараах зарчмыг мөрдөж ажиллана.

10.3.6 Өндөрт эрсдэлт эмийн жорыг бэлтгэхэд нэгж тунгийн зарчмаар бэлтгэж, нэг дор олон хоногийн тунг олгохгүй.

10.3.7 Өндөр эрсдэлт эмийг тусгай анхааруулга, өнгө бүхий шошго нааж түгээнэ

10.3.8 “Адил харагдах эм”, “Адил дуудагдах эм”-ийн шошгод ижил дуудагддаг, харагддаг үеийг ТОМ үсгээр бичнэ.

10.3.9 Тусгай орчин ба температур шаарддаг эмийг эм зүйн албанаас тасаг нэгжид олгохдоо анхааруулж олгон, тасаг нэгжид хадгалалтын тусгай горим зөв мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина.

10.4 Тасаг, нэгжид байрлах өндөр эрсдэлт эмийг хадгалах шүүгээ, тавиурт “Өндөрт эрсдэлт эм”, “Адил харагдах эм”, “Адил дуудагдах эм” гэсэн ялгах тэмдэг байршуулсан байна.

10.5 Өндөр эрсдэлт эмийг хадгалах шүүгээнд хадгалж буй эмийн жагсаалт, тоо хэмжээ, хяналтын хуудсыг байршуулж, шүүгээний орлого, зарлагыг ээлжийн сувилагч хянанана.

10.6 Өндөр эрсдэлт эмийн хэрэглээг хянах, зохицуулах

- Өндөр эрсдэлт эмийг эмчилгээнд хэрэглэх үед сувилагч хяналт тавьж ажиллах ба шаардлагатай тохиолдолд эмчийн хяналтад хийнэ.
- Судсаар хэрэглэх эмийг зориулалтын тариур болон системээр хийж, шахуурга тохиргоо, тарилгын хурд зэргийг хянан, аюулгүй ажиллагааг мөрдөнө.
- Судсаар хэрэглэх өндөр эрсдэлт эмийг шингэлсэн дуслын шингэний уут, савлагаа дээр эмийг хэрэглэж эхэлсэн огноо, цагийг тэмдэглэж, эмийн ампулыг нааж бэхэлнэ.
- Эм хэрэглэсэн арга, огноо, цаг, эмчилгээний хяналтын /шинжилгээ, амин үзүүлэлт г.м/ үзүүлэлтүүд болон эмийг хэрэглэх үед илэрсэн сөрөг нөлөө, авсан арга хэмжээний тухай болон тэмдэглэлийг эмчилгээний хуудсанд тэмдэглэнэ.
- Тасагт өндөр эрсдэлт эмийг үйлчлүүлэгчийн дэргэд түр орхих болон эмийн саванд байлгахыг хориглоно.
- Эмнэл зүйн эм зүйч тасгуудыг хариуцаж ажилладаг байх, тасгийн үйлчлүүлэгчдийн эмчилгээний хэрэглэсэн өндөр эрсдэлт эмийн жорын болон хэрэглээний хяналтыг өдөр бүр хянанана.
- Өндөр эрсдэлт эмийг хэрэглэх үед эмийн гаж нөлөө илэрсэн үед эмчлэгч эмч болон жижүүрийн эмчид яаралтай мэдэгдэж эмчилгээний арга хэмжээ авсаны дараа “Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх” арга хэмжээ авна.

- Өндөр эрсдэлт эмийн хэрэглээтэй холбоотой эмчилгээний алдаа, алдаанд ойрхон тохиолдол илэрсэн үед “Эмийн эмчилгээний алдааг бүртгэх мэдээлэх” Тохиолдол мэдээлэх, авах арга хэмжээг зохицуулах” зэрэг арга хэмжээ авна.

10.7 Эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагаа

- Эмнэл зүйн эм зүйч хариуцсан тасаг нэгжийн өндөр эрсдэлт эмийн хэрэглээ, орлого, зарлага болон хадгалалтыг тогтмол хянана.
- Эмнэл зүйн эм зүйч өндөр эрсдэлт эмийн жор бичилт эмийн хэрэглээнд проспектив болон ретроспектив судалгааг тасаг хариуцсан эмнэл зүйн эм зүйч тогтмол хийж, эмийн эмчилгээний алдаа, алдаанд ойрхон тохиолдлыг эрт илрүүлэхэд хяналт тавьж ажиллана.
- Эмнэлгийн өндөр эрсдэлт эмийн хэрэглээний хяналт, судалгааны тайланг Эм зүйн албаны дарга “Эмийн эмчилгээний хороо”-нд жил бүр тайлагнаж, эмнэлгийн нийт мэргэжилтнүүдэд мэдээлнэ.
- Эм зүйн алба эмнэлэгт хэрэглэх өндөр эрсдэлт эмийн талаар эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдээлэл, сургалт зохион байгуулах, эрсдэлээс сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулна
- Эм зүйн алба амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэгч, асран хамгаалагчдад өндөр эрсдэлт эмийн зохистой хэрэглээ, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний талаар эрүүл мэндийн боловсрол олгоно.

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭГЭЭ

Хүснэгт 7

| | | | |
|---|---|---|---|
| 1 |  | <p>Өндөр эрсдэлтэй эмийн тэмдэглэгээ</p>  | <p>Эмзүйн албанаас бүх тасгуудад тухайн анхааруулах тэмдэглэгээг эмийн гадаргууд нааж түгээлт хийнэ. Тасгууд өндөр эрсдэлтэй эмийн хадгалах газар болон шүүгээнд таних тэмдгийг байршуулна.</p> |
| 2 |   | <p>Адилхан дуудагддаг адилхан харагддаг -Look alike, sound alike харагддаг эмийн бодисын тэмдэглэгээ</p>  | <p>Эмзүйн албанаас бүх тасгуудад тухайн анхааруулах тэмдэглэгээг эмийн гадаргууд нааж түгээлт хийнэ. Адилхан дуудагддаг адилхан харагддаг эмийн хэрэгсэл хадгалагдах тавиур шүүгээнд танин тэмдгийг байршуулна.</p> |

АРВАН НЭГ: ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАРЫГ БУУРУУЛАХ, СЭРГИЙЛЭХ -REDUCE THE RISK OF HEALTH CARE-ASSOCIATED INFECTIONS.

11.1 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хэмжээнд үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гарахаас урьдчилан сэргийлэх, халдвар тарах эрсдэлийг илрүүлэх, хяналт тавих зорилготой.

11.2 Эмнэлгийн ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагаандаа стандарт сэргийлэлтийг мөрдөж ажиллана.

11.3 Стандарт сэргийлэлтэд дараах үйл ажиллагаанууд орно. Үүнд:

- Гар угаах , халдваргүйжүүлэх
- Хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх
- Амьсгалын замын эрүүл ахуйг сахих / ханиах найтаахдаа ам, хамраа халхлах/
- Мэс ажилбар, мэс засал хийхдээ халдварын эсрэг дэглэм барих
- Хурц үзүүртэй эмнэлгийн хэрэгсэлтэй аюулгүй харьцах
- Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах
- Эмнэлгийн хоолыг стандартын дагуу хадгалах, тээвэрлэх
- Эмнэлгийн орчныг цэвэрлэх, халдваргүйжүүлэх
- Эмнэлгийн зөөлөн эдлэл, цагаан хэрэглэлийг угаах, халдваргүйжүүлэх
- Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх,

боловсруулах, устгах

11.4 Стандарт сэргийлэлтийг хэрэгжүүлэхэд халдварын сэргийлэлт, хяналтын алба эмнэлгийн ажилтнуудад зөвлөгөө өгч ажиллана.

11.5 Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар эсвэл халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн гэж үзвэл эмнэлгийн ажилтан “халдварт өвчин мэдээлэх журам”-ын дагуу халдварын сэргийлэл, хяналтын албанд мэдээлж, халдвар дамжих замаас шалтгаалсан сэргийлэлтийг хийнэ. Үүнд:

- Агаарын сэргийлэлт: Эмгэг төрөгч бичил биетэн 5 микроноос жижиг хэмжээтэй дуслын хамт агаарт тархан халдвар үүсгэж буй үед / сүрьеэ, улаанбурхан, салхинцэцэг г.м/ агаарын сэргийлэлт хийнэ.

- Дуслын сэргийлэлт: Том хэмжээний дусал ам, хамрын салст болон нүдний салстад хүрснээс дамжих халдварын үед /томуу, микоплазм, Streptococcus pneumoniae-ийн халдвар, гахайн хавдар, хөхүүл ханиад г.м/ дуслын сэргийлэлт

- Хавьтлын сэргийлэлт: Халдвартай хүнтэй арьс арьсаар хүрэлцэх, орчны эд зүйлээс эсвэл эмнэлгийн тусламж үйлчилгээний үед шууд бус замаар дамжих халдварын үед /херпес вирус, хамуу, стрептококк, эмгэг бичил биетний колонизаци г.м/ хавьтлын сэргийлэлт хийнэ.

- Халдварын сэргийлэлт, хяналтын алба нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар бүрд тохирсон халдварын сэргийлэлт хяналтын тушаал журмыг хэрэгжүүлэн ажиллана

11.6 Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гарах эрсдэлээс сэргийлж эмч, эмнэлгийн ажилчид дараах үйлдлийг гүйцэтгэнэ.

11.6.1 Гарыг халдваргүйжүүлэх аргыг эрүүл мэндийн бүх ажилтнууд дараах

зааврыг мөрдөнө. Халдваргүйжүүлэх хугацаа нэг үйлдлийн хугацаа 20-30 секундээс багагүй байна.

11.6.2 Спиртэн суурьтай гар халдваргүйтгэлийн бодисыг бүх ажилтнууд зааврын дагуу хэрэглэнэ:

- Эмчлүүлэгчийн өрөөнд орохын өмнө болон орсны дараа (хаалга, хөшиг, орны орчим гэх мэт)
- Бээлий өмсөхийн өмнө
- Эмчлүүлэгчид хүрэхийн өмнө болон хүрсний дараа
- Эмчлүүлэгчийн орчин хүрэхийн өмнө болон хүрсний дараа

11.6.3 Гараа савандаж угаах /Гар угаах хугацаа 1 минут/

- Цус, бусад биеийн шингэнд хүрэлцсэний дараа
- Гар бохирдсон үед
- Бээлий тайлсны дараа

11.6.4 Эмчлүүлэгчийн өрөөнд орохын өмнө нэг удаагийн хамгаалах хувцас өмсөх ба гарахдаа тайлна.

- Бээлий- Эмчлүүлэгчийн биеийн шингэн, боолт, шарханд хүрэх бүх тохиолдолд нэг удаагийн бээлий өмсөнө. Эмчлүүлэгч хооронд бээлийг заавал солино.

- Нэг удаагийн халат, малгай - Олон эмийн тэсвэртэй нянтай эмчлүүлэгчид том талбайгаар хүрэлцэх үед (эмчлүүлэгчийг эргүүлэх, өргөх гэх мэт

 - Түлэгдэл

 - Халууралт нейтропени

 - Дархлаа дарангуйлагдсан эмчлүүлэгч

(халдвар хамгааллын журамд зааснаар)

- Амны хаалт, нүүрний хамгаалалт, нүдний шил

 - Мэс заслын амны хаалтыг эмнэлгийн бүх ажилтан, сахиур 2 цаг тутамд сольж тогтмол зүүнэ

 - N95 маск, нүүрний хаалтыг амьсгалын замын соруулга, интубаци тавих авах, амьсгалын замаас сорьц авах үйлдэл хийх

- Нүдний шил, нүүрний хаалтыг асгарсан цацагдсан биологийн шингэн цэвэрлэх, өвчтөний бие, толгой угаах, өтгөн шингэнийг ОО- д асгах зэрэгт заавал хэрэглэнэ

11.7 Тусгаарлан сэргийлэх тусламж ба нэмэлт хамгаалалтын тэмдгийг хэрэглэх БОЭТөвийн бүх тасаг нь стандарт тусгаарлан сэргийлэх өрөөтэй / Class S/ байх ба дамжих замд суурилсан халдвараас сэргийлэх нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлж болно.

11.7.1 Дараах тэмдэглэгээг эмчлүүлэгчийн өрөөний гадна байрлуулна:

- Улаан – олон эмэнд дасалтай нян



- В, С вирустай эмчлүүлэгчийг таних тэмдэг/

11.8 Нийт эмч мэргэжилтэн Өртөлтийн дараах сэргийлэлт, асгарсан цацагдсан биологийн шингэнийг цэвэрлэх дадлыг бүрэн эзэмшсэн байна.

11.9 Ажилбарыг гүйцэтгэж буй хүн хурц үзүүртэй бүх зүйлийг аюулгүй хайрцагт хаяж хэвшсэн байна (зүү, хутганы ир зэрэг).

11.10 Бүх төрлийн гуурс тавьсан, мэс засал мэс ажилбар хийсний дараа бүртгэж, тандалтын хуудас хөтөлнө.

11.11 Ариутгагдсан зүйл шалан дээр унахад ямар нэгэн гэмтэлгүй байсан ч бохирлогдсон гэж үзнэ

11.12 Эрүүл зүйн шинжилгээнд хамрагдах

11.12.1 ХСХА-ны Тасаг нэгжийн орчны агаарын болон арчдасны шинжилгээг улирал тутам авч дүгнэлт гарган шаардлагатай хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

11.12.1 Эмч эмнэлгийн мэргэжилтэн нян тээгч илрүүлэх шинжилгээний графикийг ХСХА-ны дарга гаргах ба тасаг нэгжийн эмч мэргэжилтэн тогтоосон графикт хугацаанд шинжилгээнд бүрэн хамрагдана. Нян тээгч илрүүлсэн илэрсэн тохиолдолд эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг тухайн тасаг нэгжийн эрхлэгч, ХСХА-ны тархвар судлаач нар хамтран хэрэгжүүлнэ.

11.12.3 ЭТҮХХалдварын сэжигтэй тохиолдолд бүрт халдварын эрсдлийг тогтоох шинжилгээ, тандалт судалгааг зааврын дагуу хийж хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг ХСХА, тасаг нэгжийн эрхлэгч нар хамтран хүлээнэ.

11.12 ХСХА-ны Олон эмийн дасалтай нянгийн халдвар илэрсэн тохиолдол бүрийг ЭТҮЧАБА-нд мэдээлэн хамтран ажиллана.

11.13 Байгууллагын нянгийн тэсвэржилтийн судалгаа мэдээллийн лабораторийн тасгийн эрхлэгч улирал тутамд гарган мэдээллээр хангаж ажиллана.

11.14 Нянгийн эсрэг эмийн хэрэглээний судалгааг улирал тутамд клиник эм зүйч гарган, нянгийн эсрэг эмийн жагсаалтыг батлуулан эмч нарыг мэдээллээр хангаж ажиллана.

11.15 Эм зүйн албанаас антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр сургалт мэдээлэл тогтмол хийдэг байна .

АРВАН ХОЁР: ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

1.1 БОЭТ-ийн ЭМТҮЧАБА нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах нийтлэг журмыг тасгийн эрхлэгч, сувилахуйн арга зүйч, чанарын багийн гишүүдэд танилцуулах сургалт мэдээллээр ханган гарын үсгээр баталгаажуулна.

1.2 Тасгийн эрхлэгч нар тасаг доторх сургалтыг бүрэн хариуцна.

1.3 БОЭТ –ийн санхүүгийн алба, эм зүйн алба нь үйлчлүүлэгчийн аюулгүй

байдлыг хангах нийтлэг журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, туслах материалаар бүрэн хангана.

1.4 Журмын хэрэгжилтийн хяналт үнэлгээг дараах хүснэгтийн дагуу хийнэ.

Хүснэгт 8

| № | Үнэлэх үйл ажиллагаа, чиглэл | Үнэлгээ хийх аргачлал, материал | Үнэлгээ хийх давтамж | | Сар бүр |
|---|---|--|------------------------|--|--|
| | | | Өдөр бүр | 14 хоног тутамд | |
| 1 | Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах | Case тохиолдол, бэлтгэсэн шалгуур | Тасгийн эрхлэгч САЗ | Сувилахуйн алба Чанарын алба ХСХ алба | Чанарын алба ХСХ алба Сувилахуйн алба Гүйцэтгэлийн удирдлага дотоод хяналтын алба хамтарсан баг |
| 2 | Үр дүнтэй харилцааг бий болгох | Case тохиолдол, бэлтгэсэн шалгуур | Тасгийн эрхлэгч САЗ | Сувилахуйн алба Чанарын алба ХСХ алба | |
| 3 | Шинжилгээний үр дүн аюултай, сэрэмжлүүлэх хязгаарт хүрсэн тохиолдолд авах арга хэмжээ | Бэлтгэсэн шалгуурын дагуу цахим программ, бүртгэл журнал | Тасгийн эрхлэгч САЗ | Сувилахуйн алба Чанарын алба | |
| 4 | Өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдал | Case тохиолдол, бэлтгэсэн шалгуур | Тасгийн эрхлэгч САЗ | Тасаг хариуцсан эм зүйч нар Сувилахуйн алба | |
| 5 | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар бууруулах | Бэлтгэсэн шалгуурын дагуу, тохиолдолд суурилсан. | Тасгийн эрхлэгч САЗ | ХСХ алба | |

| | | | | | |
|---|--|--|------------------------|-----------------|----------------|
| 6 | Унах эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх | Хөтлөгдсөн хуудас, Case тохиолдол, бэлтгэсэн шалгуур | Тасгийн эрхлэгч САЗ | Сувилахуйн алба | |
| 7 | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах нийлэг журмын сургалт мэдээлэл | Онол, дадлага хавсарсан байдлаар | Тасгийн эрхлэгч САЗ | Сургалтын алба | |
| 8 | Гадаад дотоод ээлтэй орчны үнэлгээ | Газар дээрх үнэлгээ | Тасгийн эрхлэгч САЗ | Сар бүр | Улирал бүр ХАБ |

12.5 Энэхүү журмын хэрэгжилтийн үнэлгээгээр зөрчил илэрсэн, дундаж үнэлгээрээр хангалтгүй үнэлэгдсэн ажилтан албан хаагч тасаг нэгжийн үр дүнгийн урамшууллыг 10% -аар хасч тооцно.